

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 3-р сарын 26 өдөр

Улаанбаатар хот

“Блюскай Секьюритиз ҮЦК” ХК-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 3 дүгээр сарын 26-ны өдрийн 13 цаг 00 минутанд Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төвийн 5-р давхарт 502 тоот өрөөнд эхлэв.

Хуралд 781555 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч Г.Оюунболд, Р.Отгонбат, А.Ариунтуяа, А.Ариун-Эрдэнэ, Э.Төгс-Очир, “Мезза Файнэншл Групп” ХХК Камолиддин Талипов нарын 6 хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд энэ нь нийт саналын 93,7 хувь болж байгааг тооллогын комиссын дарга хурал зохион байгуулах комисс болон хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэж, хурал хүчин төгөлдөрт тооцох тухай тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулснаар хурал эхлэв.

Хурлын дарга Г.Оюунболд хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд :

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
4. Нэмэлт хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
5. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
6. Бусад.

ТУЗ-ийн дарга Г.Оюунболд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Компани Брокерийн үйл ажиллагааны хүрээнд 628 иргэнд үнэт цаасны данс нээсэн байна. Давхардсан тоогоор 18450 иргэнд данс холбох, овог нэр өөрчлөх, хувьцаа шилжүүлэх хүсэлт зэргийг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн. 2024 онд компани нь мөнгө угаалт, терроризмтой тэмцэх дотоод журмыг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монгол банкны дүрэм журмын дагуу боловсруулнаа явуулж холбогдох тайлан мэдээг, цаг тухайд нь хүргүүлсэн байна. Санхүүгийн хувьд ашигтай ажиллаагүй ч гэсэн харилцагчдын тоогоо нэмсэн. Аудитлагдсан санхүүгийн тайланг та бүхэнд тараасан байгаа Асуух зүйл байвал асуугаарай. Компани нь Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газарт харъяалагддаг. Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газраас ээлжит шалгалт хийгдсэн ба ямар нэгэн зөрчил илрээгүй тул торгууль болон арга хэмжээ авагдаагүй болно. Компани өмнөх жилүүдэд хуримтлагдаад байсан нийгмийн даатгалын өрний 50 хувийг төлж барагдуулсан. Санхүүгийн баталгаажсан тайланг та бүхэнд танилцуулж байна. Асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй

Хурлын дарга Г.Оюунболд : Хэлэлцэх асуудлын дараагийн зүйл Компанийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг та бүхэнд хэвлэмэл байдлаар тараасан байгаа. Бид 2025 онд дилер, андеррайтер болон гадаад арилжаанд зуучлах эрх, хөрөнгө

оруулалтын зөвлөх эрх авах төлөвлөгөөтэй байна. Энэ зах зээлд цаашид ашигтай ажиллахын тулд андеррайтерийн эрх авах зайлшгүй шаардлагатай байна. Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдэх шаардлагатай тохиолдолд ТУЗ бүрэн эрхийнхээ хүрээнд хийх эрхтэй. Андеррайтерийн эрх авах нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд томоохон стратегийн хөрөнгө оруулагч хэрэгтэй байгаа тул цаашид бидэнтэй хамт энэ зах зээлийг ойлгож ажиллах хөрөнгө оруулагчийг олж хамтран ажиллах гол төлөвлөгөөтэй байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж батлав.

Хурлын дарга Г.Оюунболд : Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч ашигтай ажиллах хэмжээний орлого орохгүй байгаа, татвар, нийгмийн даатгалд хуримтлагдсан өр төлбөрүүдийг төлж барагдуулахад зардал гарч байгаа учир хувьцаа эзэмшигчдэд энэ жил ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэнийг танилцуулж байна.

Хувьцаа эзэмшигчид: Бүгд санал нэгтэй зөвшөөрөв.

Хувьцаа эзэмшигчид: Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Р.Отгонбат: Нэмэлт хувьцаа гаргах, тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшүүлэх эрх эдлүүлэх эсэх, шаардах эрх хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэх шаардлагатай байна.

Компанийн үйл ажиллагааны чиглэлд дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа болон андеррайтерийн үйл ажиллагааг нэмж авах гэж байгаа тул хувьцаат компани учраас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Үүнийг нэмэлт хувьцаа гаргах замаар нэмэгдүүлэх ёстой. Таван тэрбум хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцаа нэмж гаргах, нэмж хувьцаа гаргах гэж байгаатай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэх саналтай байна. Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх эрх, шаардар эрх хэрэгжүүлэхийг ТУЗ-д өгье. Үйл ажиллагааны чиглэл нэмэх, хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх, нэр өөрчлөх эрхийг компанийн ТУЗ-д олгох саналтай байна. Шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулагчдын саналыг хүлээн авч компанийг хуульд заасан хэлбэрүүдийн аль тохирхоор нь өөрчлөн байгуулах саналтай байна.

Хувьцаа эзэмшигчид: Зөвшөөрч байна. Андеррайтерийн тусгай зөвшөөрлийг авахад шаардлагатай бичиг баримт болон их хэмжээний сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх эрхийг ТУЗ-д бүрэн өгч дээрх зөвшөөрлүүдийг авах хэрэгтэй. Холбогдох дүрэм журам, төсөл, төсөв, төлөвлөгөө зэргийг батлах эрхийг мөн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгохоор бүгд санал нэгтэй зөвшөөрөв.

Хурлын дарга Г.Оюунболд : Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.4. /Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад бусад гэсэн хэсэг байх шаардлагатай бол энэ нь зөвхөн Компанийн тухай хуулийн 62.1-д заасан асуудал байна/-д заасны дагуу Бусад гэх асуудлын хүрээнд “Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох” тухай хэлэлцье. Мөн компанийн гэрчилгээ хуучирсан, дахин тэмдэглэгээ хийх зай үлдээгүй тул компанийн гэрчилгээг дахин авах асуудлыг шийдье. Цаашид компанийн гэрчилгээ, тамгыг шинэчлэн авах шийдвэрийг ТУЗ-д өгөх саналтай байна. Энэ нь хурал зарлах гэж цаг алдахгүй байх, компанийн үндсэн үйл ажиллагааг доголдуулахгүй байх сайн талтай гэж үзэж байна. Тиймээс энэ үүргийг ТУЗ-д хариуцуулъя.

Хувьцаа эзэмшигчид: Санал нэгтэй дэмжиж байна. Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсөний дараа хурлын дарга Хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож, нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна. Хүчингүй саналын хуудас гараагүй.

“ Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК-ийн 2025 оны 3-р сарын 26 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэж хангалттай гэж дүгнэлээ.
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хурлаар хэлэлцэгдсэнээр баталж, холбогдох төсөл боловсруулахыг даалгав.
3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөв.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнав.
5. Нэмэлт хувьцаа гаргах, тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшүүлэх эрх эдлүүлэх эсэх, шаардах эрх, компанийн гэрчилгээг дахин шинээр авах эрхийг ТУЗ-д хэрэгжүүлэх үүрэг өгөв. Мөн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулах, компанийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэн зөвшөөрөн шийдвэрлэв. ТУЗ-ийн гишүүдийг сонгов.

Хурлын дарга Г.Оюунболд:– Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа.

“ Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 14 цаг 00 минутад дуусав.

Хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:



Г.Оюунболд

А.Амирлан